

УВС АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ДЭРГЭДЭХ
ИРГЭНИЙ ЗӨВЛӨЛ

20/Бонь/Барын 26ны өдөр

Дугаар 01.

Улаангом хот.

ЗӨВЛӨМЖ

. Цагдаагийн байгууллага нь 2014 онд дэвшигүүлсэн зорилтоо хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гаргаж явц , үр дүнг тухай бүр тооцож ажилласан байна.

Тус цагдаагийн газраас цагдаагийн байгууллагын ажил үйлчилгээг иргэд олон нийтэд ил тод, шуурхай хүргэх , иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах зорилгоор “ Нээлттэй хаалганы өдөр ” арга хэмжээг б удаа хийж , хууль сурталчлах , гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийсэн ажлаа иргэд олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулж ажилласан байна.

Цагдаагийн газрын “Иргэдийн гомдол, мэдээлэл хүлээн авах , эрх зүйн туслалцаа үзүүлэх танхим”- д байгууллагын эрхэм зорилго , үйл ажиллагааны талаархи мэдээлэл, удирдлагуудаас иргэдийн санал хүсэлт хүлээн авч уулзах цагийн хуваарь , Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм , Төрийн албан хаагчийн эрхэмлэх есөн зүйл , алба хаагчдийн өрөөний байршил, дугаар, цол, нэр, албан тушаал, үйл ажиллагаа, үйлчилгээний чиглэл, иргэд цагдаагийн байгууллагад гомдол, хүсэлтээ хэрхэн гаргах, хаана, хэнд хандаж эрх зүйн зөвлөгөө , туслалцаа авах, гомдол хүсэлтээ хэрхэн шийдвэрлүүлэхтэй холбоотой зөвлөмж, зэрэг мэдээллийг байршуулж иргэдийг чирэгдүүлэхгүй шуурхай үйлчлэх нөхцөл, боломжийг бүрдүүлэн ажилласан байна.

Байгууллага , алба хаагчийн зүгээс соёлтой харилцааг эрхэмлэн , иргэдийг “ Угтан авах ” үйлчилгээг нэвтрүүлсэн нь иргэд , олон нийтэд харилцааны эерэг таатай уур амьсгалыг төрүүлж , цагдаагийн байгууллагад хандах иргэдийн итгэл үнэмшил , хандлагыг дээшлүүлэхэд зохих үр дүнгээ өгсөн байна.

Тус байгууллага нь төр , олон нийтийн байгууллагатай хамтран аймгийн хэмжээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх , илрүүлэх, таслан зогсоох , нийтийн хэв журам сахиулж , иргэдийн амар тайван амьдрах, ажиллах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор нэлээд хэмжээний ажил, арга хэмжээ зохион байгуулан хэрэгжүүлж зохих үр дүнд хүрсэн байна.

Цагдаагийн газрын 2014 оны ажлын тайлан хэлэлцээд доорхи зөвлөмж өгч байна.

1. Цагдаагийн байгууллагын тайланг Иргэний зөвлөлд ирүүлэхдээ Хууль зүйн сайдын 2014 оны А/89 дүгээр тушаалын 1,2-р хавсралтаар баталсан журамуудыг баримтлан ажиллах.

Цаашдаа Иргэний зөвлөл, оршин суугчдад Цагдаагийн байгууллагын тайлан тавихдаа журамд заасны дагуу тайлан боловсруулахад анхаарах.

2. Иргэний зөвлөлд ирүүлж байгаа тайланд Цагдаагийн байгууллагын санхүүгийн гол гол үзүүлэлтүүдийг тусгаж , тайлан тавих журмын 4 дүгээр зүйлийн 4,1-ын "а" заалтад дурдагдсан зүйлийг оруулж тайлагнах .

3. Тус аймагт гараад байгаа болон буурахгүй байгаа гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг судлах судалгааны баг байгуулж , ул суурьтай нарийвчилсан судалгаа хийж үнэлэлт, дүгнэлт боловсруулж цаашид яаж бууруулах , арилгах арга хэмжээг тодорхой төлөвлөж ажиллах.

4. 2014 оны тайлан үйл ажиллагааны тайлан болсон байна . Цаашид тодорхой үйл ажиллагаа явуулаад ямар үр дүнд хүрэв гэдгийг үр ашиг, үр нөлөө талаас нь харж дүгнэлттэй хандах .

ДАРГА

Н. ГЭЖЭЭ

